

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

(Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт)

# Агуулга

	Хуудас
Компанийн Мэдээлэл	1
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Хараат Бус Аудиторын Тайлан	3
Санхүүгийн Байдлын Тайлан	6
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд	10

**Ди Би Эм Лизинг ХХК**  
**Компанийн Мэдээлэл**

Албан ёсны хаяг:

Нарны Зам-87, 6 давхар  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо  
Улаанбаатар 14230,  
Монгол Улс

Төлөөлөн Удирдах Зөвлөл:

Я. Сод-Эрдэнэ (Дарга)  
Н. Батчимэг  
Л. Тэмүүжин  
Г. Амартүвшин  
Д. Сувдаа  
Д. Анар  
Ц. Оюунчимэг  
Ц. Базаррагчаа  
М. Энхтулга

Хараат бус аудитор:

Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот

## Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Компанийн удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Компанийн удирдлага нь Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг тодруулгын хамт бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Ди Би Эм Лизинг ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Г. Пүрэвсүрэн  
Албан тушаал: Гүйцэтгэх Захирал

A handwritten signature in black ink, appearing to read "D. Ayurzana".

Д. Аюурзана  
Албан тушаал: Ерөнхий Нягтлан Бодогч

Монгол Улс,  
Улаанбаатар хот

2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр





Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар-14240,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө 17  
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас: +976 7011 8101  
Факс: +976 7011 8102  
[www.kpmg.com/mn](http://www.kpmg.com/mn)

## Хараат Бус Аудиторын Тайлан

Ди Би Эм Лизинг ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчид:

### Дүгнэлт

Бид Ди Би Эм Лизинг ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн санхүүгийн тайлан нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



## Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.



## Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага, үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр

*Mark Ebert*

Баталгаажуулсан:

*G. Soyolmaa*

Г. Соёлмаа  
Ерөнхий Захирал

Баталсан:

*Mark Ebert*

Марк Эбэрст  
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу. Энэхүү тайланг зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
**Санхүүгийн Байдлын Тайлан**  
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

	<u>Тодруулга</u>	<u>2019 Мян.төг</u>	<u>2018 Мян.төг</u>
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	42,573,986	769,606
Хугацаатай хадгаламж	6	10,292,762	8,200,204
Дансны болон бусад авлага	7	68,062	79,448
Бусад хөрөнгө	8	51,241	51,917
Түрээсийн авлага	9, 23	74,452,393	67,776,257
Түрээслэх зорилгоор худалдаж авсан хөрөнгө	10	-	5,900,000
Үндсэн хөрөнгө	11	277,337	295,443
Биет бус хөрөнгө		8,339	8,750
<b>Нийт хөрөнгө</b>		<u>127,724,120</u>	<u>83,081,625</u>
<b>Өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	12	182,704	5,993,567
Орлогын албан татварын өглөг	21	51,040	34,878
Түрээсийн өр төлбөр (2018: Санхүүгийн түрээсийн өр төлбөр)	13	111,815	134,234
Зээл	14	24,569,455	66,124,130
Хойшлогдсон татварын өр төлбөр	21	82,341	-
<b>Нийт өр төлбөр</b>		<u>24,997,355</u>	<u>72,286,809</u>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	15	100,000,000	10,000,000
Хуримтлагдсан ашиг		2,726,765	794,816
<b>Нийт эздийн өмч</b>		<u>102,726,765</u>	<u>10,794,816</u>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>		<u>127,724,120</u>	<u>83,081,625</u>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Ашиг, Алдагдал Болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	<u>Тодруулга</u>	<u>2019</u> <u>Мян.төг</u>	<u>2018</u> <u>Мян.төг</u>
Хүүгийн орлого	16	7,058,101	4,239,874
Хүүгийн зардал	17	(3,075,912)	(2,186,371)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>		<b>3,982,189</b>	<b>2,053,503</b>
Үйл ажиллагааны зардал	18	(2,056,605)	(1,057,932)
Бусад орлого, цэвэр	19	856,009	387,149
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>2,910,380</b>	<b>1,382,720</b>
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал	20	(624,199)	(548,166)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>2,157,394</b>	<b>834,554</b>
Орлогын татварын зардал	21	(225,445)	(127,161)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг ба нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>1,931,949</b>	<b>707,393</b>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
**Өмчийн Өөрчлөлтийн Тайлан**  
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	Хувьцаат капитал Мян.төг	Хуримтлагд -сан ашиг Мян.төг	Нийт Мян.төг
<b>2018 оны 01 дүгээр сарын 01</b>	10,000,000	87,423	10,087,423
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>			
Тайлант жилийн цэвэр ашиг	-	707,393	707,393
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>	-	707,393	707,393
<b>2018 оны 12 дугаар сарын 31</b>	<u>10,000,000</u>	<u>794,816</u>	<u>10,794,816</u>
Нягтлан болох бүртгэлийн бодлогын өөрчлөлт СТОУС 16	-	-	-
<b>2019 оны 01 дүгээр сарын 01</b>	10,000,000	794,816	10,794,816
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>			
Тайлант жилийн цэвэр ашиг	-	1,931,949	1,931,949
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>	-	1,931,949	1,931,949
<b>Эзэмшигчтэй хийсэн ажил гүйлгээ</b>			
Гаргасан энгийн хувьцаа	90,000,000	-	90,000,000
<b>Эзэмшигчтэй хийсэн ажил гүйлгээ</b>	<u>90,000,000</u>	<u>-</u>	<u>90,000,000</u>
<b>2019 оны 12 дугаар сарын 31</b>	<u>100,000,000</u>	<u>2,726,765</u>	<u>102,726,765</u>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
**Мөнгөн Гүйлгээний Тайлан**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	<i>Тодруулга</i>	2019 Мян.төг	2018 Мян.төг
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Тайлан жилийн цэвэр ашиг		1,931,949	707,393
Тохируулгууд:			
Элэгдэл болон хорогдол	11,18	66,820	39,271
Хүүгийн орлого	16	(7,058,101)	(4,239,874)
Хүүгийн зардал	17	3,075,912	2,186,371
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал	20	624,199	548,166
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	19	-	(1,338)
Валютын ханшны хэрэгжээгүй цэвэр олз	19	(823,411)	(153,097)
Орлогын татварын зардал	21	225,445	127,161
		(1,957,187)	(785,947)
<b>Хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт:</b>			
Хугацаатай хадгаламж	6	(2,184,190)	(3,557,951)
Дансны болон бусад авлага	7	12,200	(70,949)
Бусад хөрөнгө	8	3,353	(130,667)
Түрээсийн авлага	9	(4,523,708)	(30,257,728)
Түрээслэх зорилгоор худалдаж авсан хөрөнгө	10	5,900,000	(5,900,000)
Дансны болон бусад өглөг	12	(5,814,148)	5,923,447
Төлсөн орлогын албан татвар		(126,942)	(111,448)
Хүлээн авсан хүүгийн орлого		6,206,435	4,301,109
Төлсөн хүүгийн зардал		(3,409,732)	(2,247,704)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(5,893,919)</b>	<b>(32,837,838)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	11	(57,155)	(93,065)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(450)	(8,250)
Худалдсан үндсэн хөрөнгө		-	27,025
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(57,605)</b>	<b>(74,290)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Санхүүгийн түрээсийн өр төлбөр төлсөн	13	(22,419)	(7,834)
Зээл авсан	14	15,467,466	39,120,491
Зээлийн эргэн төлөлт	14	(57,766,407)	(11,081,794)
Энгийн хувьцаа гаргалтаас хүлээн авсан	15	90,000,000	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>47,678,640</b>	<b>47,678,640</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн (бууралт) /өсөлт</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5	769,606	5,650,871
Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан		(74,037)	-
Мөнгөн хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл		151,301	-
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5</b>	<b>42,573,986</b>	<b>769,606</b>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

### 1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид “Компани” гэх) нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан. Компанийг Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК бүрэн эзэмшдэг. Компанийн регистрийн дугаар нь 6196233 болно. Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны Зам 87, 6 давхар.

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан хуулын этгээд бөгөөд Монгол Улсын санхүүгийн түрээсийн тухай хууль, Иргэний хууль, Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь дунд болон урт хугацаатай гэрээний дагуу санхүүгийн түрээсийг олгодог. Компани нь Монгол Улсын хөгжилд стратегийн чухал ач холбогдолтой салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг.

### 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

#### 2.1. Тайлагналын нийцэл

Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэсэн болно. Энэхүү санхүүгийн тайлан нь СТОУС 16 Түрээс-ийг мөрдсөн анхны санхүүгийн тайлан юм. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын холбогдох өөрчлөлтүүдийг Тодруулга 2.3 болон 2.10-д толилуулсан болно.

Тайлант жилийн толилуулгад нийцүүлэх зорилгоор зарим тоон мэдээллийг дахин ангилсан болно. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг Тодруулга 2.3-д толилуулсан болно. Компанийн удирдлагаас санхүүгийн тайланг 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр зөвшөөрч батлав.

#### 2.2. Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн.

Бүх санхүүгийн мэдээллийг тусгайлсан хэсэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлсэн.

#### 2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

Компани нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн СТОУС 16 Түрээс-ийг мөрдөж эхэлсэн. Бусад хэд хэдэн шинэ стандартууд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн боловч эдгээр стандартууд нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй.



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт (үргэлжлэл)

#### **СТОУС 16 Түрээс**

Түрээслэгчийн хувьд Компани нь оффисын талбай түрээсэлдэг. Компани өмнө нь түрээсийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл, өгөөжийн дийлэнх хэсгийг шилжүүлсэн эсэх үнэлгээнд үндэслэн түрээсийг үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс гэж ангилдаг байсан. СТОУС 16-ийн дагуу Компани нь хэрэгжих боломжтой бөгөөд СТОУС 16-ийн чөлөөлөх нөхцлүүдийг хангаагүй түрээсийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Компани нь СТОУС 16-г хэрэгжүүлэхдээ өөрчилөн буцаан мөрдөх аргыг ашиглан хэрэгжүүлсэн тул харьцуулсан мэдээллийг дахин тайлагнаагүй ба тухайн харьцуулсан мэдээллийг НББОУС 17, НББОУСХТ 4-ийн дагуу тайлагнасан. НББОУС 17, НББОУСХТ 4-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дэлгэрэнгүй мэдээллийг тусад нь тодруулсан болно.

Компанийн оффисын талбай түрээслэх гэрээ нь нэг жилийн хугацаатай бөгөөд Компани гэрээг дуусгавар болох үед сунгах боломжтой боловч Компани, түрээслүүлэгч аль аль нь харилцан зөвшөөрөл авахгүйгээр багахан хэмжээний торгуулийг төлж цуцлах боломжтой. Тиймээс энэхүү түрээс нь СТОУС 16-ийн түрээсийн тодорхойлолтын дагуу хэрэгжих боломжгүй ба СТОУС 16 нь Компанийн санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлээгүй болно.

Түрээслүүлэгчийн хувьд, Компанийг СТОУС 16-руу шилжихтэй холбоотойгоор түрээсийн үйл ажиллагааны түрээслүүлэгч талын бүртгэлд ямар нэг залгуулга хийхийг шаардахгүй. Компани нь түрээсийн бүртгэлгээ СТОУС 16-г хэрэгжүүлж эхэлсэн анхны өдрөөсөө эхлэн стандартын дагуу хөтөлсөн.

Компани нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсэг тус бүрт гэрээний үнийг хуваарилахын тулд СТОУС 15 Харилцагчтай Байгуулсан Гэрээний Орлого-ыг нэвтрүүлсэн.

#### **НББОУС 17-ийн дагуу санхүүгийн түрээс гэж ангилсан түрээсүүд**

Компани нь машиныг санхүүгийн түрээсээр худалдан авсан. Энэхүү түрээсийг НББОУС 17-ын дагуу санхүүгийн түрээс гэж ангилсан. Уг санхүүгийн түрээсийн хувьд, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийн дансны үнийг тухайн өдрийн өмнөхөн НББОУС 17-ын дагуу түрээсийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийн дансны үнээр тодорхойлсон.

#### **Шилжилтийн нөлөөлөл\***

СТОУС 16-руу шилжихэд, Компани нь ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Шилжилтийн нөлөөг дараах хүснэгтэнд хураангуйлан харуулав:

2019 оны 01 дүгээр сарын 01  
Мян.төг

Үндсэн хөрөнгөөр тайлагнасан ашиглах эрхтэй хөрөнгө	149,430
Түрээсийн өр төлбөр	134,234

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусгавар болох хугацаа нь 3 сар болон түүнээс богино хугацаатай бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөх өчүүхэн эрсдэл бүхий бэлэн мөнгө, банкин дахь хугацаагүй хадгаламж болон түргэн хөрвөх чадвартай богино хугацаат хөрөнгө оруулалт (үндсэндээ банкин дахь хугацаат хадгаламж)-аас бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр тайлагнадаг.

### 2.5. Санхүүгийн хэрэгслүүд

#### (i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд

Компани нь уг хэрэгслийн гэрээний заалтад оролцогч тал болсон тохиолдолд санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Дансны авлагыг анх үүссэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Бусад бүх санхүүгийн хөрөнгийг Компани нь уг хэрэгслийн гэрээний нөхцөлд тал болох үед анх хүлээн зөвшөөрнө.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг (хэрэв идэвхитэй зах зээл дээр жишиг үнэ байхгүй тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр бүхий дансны авлага биш бол) ба санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнэ дээр тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмждэг. Идэвхитэй зах зээлд зах зээлийн жишиг үнээр арилжаалагддаггүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг түүний өртгөөр хэмжинэ

#### *Санхүүгийн хөрөнгүүд*

Анх хүлээн зөвшөөрөхдөө санхүүгийн хөрөнгийг: хорогдуулсан өртөг, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-өрийн хөрөнгө оруулалт, БДОБҮЦ-ээр илэрхийлсэн өмчийн хөрөнгө оруулалт, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнийн аль нэгээр хэмжинэ.

Компани санхүүгийн хөрөнгийг удирдах бизнес загвараа өөрчилснөөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн ангилалыг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед огт өөрчлөхгүй. Өөрөөр хэлбэл, бизнес загварын өөрчлөлтөнд орсон бүх санхүүгийн хөрөнгийг тухайн өөрчлөлт орсон анхны тайлант хугацааны эхний өдөр дахин ангилна.

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангаж байвал тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай; болон
- гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог;



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.5. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)

*Санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)*

Өрийн хөрөнгө оруулалт нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангаж байвал тухайн өрийн хөрөнгө оруулалтын санхүүгийн хөрөнгийг БДОБҮЦ-ээр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай; болон
- гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог

Дээр дурдсан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, эсвэл БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөр гэж ангилагдаагүй бүх санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмждэг.

*Санхүүгийн хөрөнгүүд – Бизнесийн загварын үнэлгээ*

Компани нь бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн багцын түвшинд хийдэг бөгөөд энэ нь бизнесийг удирдаж буй арга замыг хамгийн сайн илэрхийлдэг ба удирдлага мэдээллээр хангагдсан байдаг. Авч үзсэн мэдээлэлд дараах зүйлс багтана:

- багцад зориулсан бодлого, зорилтууд, эдгээр бодлогын практик үйл ажиллагаа. Үүнд удирдлагын стратеги нь гэрээгээрх хүүгийн орлогоо олох, тодорхой хүүний түвшний үзүүлэлтийг хадгалах, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг түүнтэй холбоотой аливаа өр төлбөрийн хугацаа эсвэл хүлээгдэж буй мөнгөн зарлагын урсгал эсвэл хөрөнгийг борлуулснаар бий болох мөнгөн гүйлгээтэй тохируулах эсэх;
- багцийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, Компанийн удирдлагад тайлагнасан эсэх;
- бизнесийн загварт (мөн тухайн бизнесийн загварт багтсан санхүүгийн хөрөнгүүдэд) гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа эсэх;
- бизнесийн менежерүүдийг хэрхэн урамшуулалыг хэрхэн олгодог вэ – жишээ нь олговор нь хөрөнгийн бодит үнэ цэнээр эсвэл хуримтлагдсан гэрээний мөнгөн гүйлгээний үнэд суурилсан эсэх; болон
- өмнөх хугацааны санхүүгийн хөрөнгийн борлуулалтын давтамж, хэмжээ, хугацаа, энэхүү борлуулалтын шалтгаанууд болон ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны хүлээлт

Санхүүгийн хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангахгүй байх тохиолдолд үүнийг борлуулалт гэж авч үзэхгүй бөгөөд Компанийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх зарчимтай нийцтэй байна.

Арилжаалах зорилгоор эзэмшиж эсвэл удирдаж буй бөгөөд гүйцэтгэлийг бодит үнэ цэнэд суурилан үнэлдэг санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмждэг.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.5. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)

*Санхүүгийн хөрөнгүүд – Гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрөөс бүрдсэн эсэхийн үнэлгээ*

Энэ үнэлгээний зорилгоор “үндсэн” гэж анх хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэлнэ. “Хүү” гэдэг нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба тодорхой хугацааны туршид эргэлтэнд байгаа үндсэн дүнтэй холбоотой зээлийн эрсдэлийн хувьд болон үндсэн зээлийн бусад эрсдэл, өртөг (жишээлбэл, хөрвөх чадварын эрсдэл ба захиргааны зардал гэх мэт), мөн түүнчлэн ашгийн зөрүүг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийн гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн зориулалттай байгаа эсэхийг үнэлэхэд Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцлийг авч үздэг. Үүнд санхүүгийн хөрөнгө нь энэ нөхцөлийг хангаж чадахгүй байхаар ямар нэгэн гэрээний мөнгөн гүйлгээний цаг хугацаа буюу дүнг өөрчлөх боломжтой нөхцөл агуулдаг эсэхийг үнэлэхэд оршино. Энэ үнэлгээг хийхдээ Компани дараах зүйлсийг авч үзсэн болно:

- мөнгөн гүйлгээний дүн буюу хугацааг өөрчлөхөд гарах болзошгүй үйл явдал;
- гэрээний купоны ханш, хувьсах хэмжигдэхүүний шинж чанарыг багтаасан болзошгүй нөхцлүүд;
- урьдчилгаа төлбөр ба өргөтгөлийн онцлог; болон
- Компанийг тодорхой хөрөнгөөс авах үр ашгийг хязгаарласан нөхцөлүүд (жишээ нь буцаах эрхгүй нөхцөлүүд).

Урьдчилгаа төлбөрийн дүн нь үндсэн төлбөр ба зээлийн хүүгийн төлбөрийг үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн дүнгээр барагдуулсан бол гэрээний эрт дуусгавар болох үндэслэлтэй нэмэлт нөхөн төлбөрийг багтааж болно. Хөнгөлөлттэй эсвэл гэрээнд заасан урамшуулалтай үнээр худалдан авсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, урьдчилгаа төлбөр нь гэрээнд тусгасан нэрлэсэн дүн болон (төлөгдөөгүй байгаа) гэрээнд тусгасан хүүгийн хуримтлагдсан дүнгээр (мөн гэрээг заасан хугацаанаас өмнө цуцласны нэмэгдэл нөхөн олговрыг тооцсон байж болно) бодитойгоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байвал зөв тайлагнасан болох бөгөөд, урьдчилж төлсөн төлбөрийг анхны хүлээн зөвшөөрөлтөөр зөвшөөрвөл бодит үнэ цэнэ нь ач холбогдолгүй болох юм.

*Санхүүгийн хөрөнгө – Дараа үеийн хэмжилт болон олз ба гарз*

Бодит үнэ цэнэтэй санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайланд үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмждэг. Аливаа хүүгийн орлого эсвэл ногдол ашгийн орлого зэрэг багтсан цэвэр олз ба гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үеүдэд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Хорогдуулсан өртгийг үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулдаг. Хүүгийн орлого, гадаад валютын ханшийн олз, гарз ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Аливаа үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз эсвэл гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.5. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

#### (ii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл тухайн хэрэглүүрийн гэрээний нөхцөл, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын дагуу бусад санхүүгийн өр төлбөр хэмээн ангилдаг. Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийн нэг хэсэг болсон тохиолдолд уг санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

*Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр*

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтын санхүүгийн өр төлбөр болон уг байдлаар анх хүлээн зөвшөөрөгдсөн өр төлбөрийг оруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих ба өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олж авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

*Бусад санхүүгийн өр төлбөр*

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрт ангилна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеэр бусад санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээс худалдан авалттай шууд хамаарал бүхий ажил гүйлгээний зардлыг хассан дүнгээр хэмждэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг дуусгавар болох үед нь (гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон гэх мэт) санхүүгийн байдлын тайландаа үл хүлээн зөвшөөрдөг.

*Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь*

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

### 2.6. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын (ХБА) санг дараах үед хүлээн зөвшөөрдөг:

- хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгө; болон
- БДОБҮЦ-ээр илэрхийлэгдсэн өрийн хөрөнгө оруулалт.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.6. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Компани дор заасан 12 сарын хугацаанд ХБА-ын хэмжээгээр хэмжсэнээс бусад тохиолдолд зээлийн алдагдлын санг, нийт гэрээний хугацаанд ХБА-ын сантай тэнцэх хэмжээгээр тооцдог:

- тайлагналын өдрөөр зээлийн эрсдэл бага байхаар тодорхойлогдсон өрийн үнэт цаас; болон
- бусад өрийн үнэт цаас болон банкны балансны зээлийн эрсдэл нь (өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүрийн гэрээний хугацааны туршид үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл) анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц өсөөгүй.

Дансны авлага болон гэрээний хөрөнгийн хувьд алдагдлыг үргэлж гэрээний хугацаатай тэнцэх ХБА-тай байхаар хэмждэг. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш болон ХБА-г тооцох үед мэдэгдэхүйц хэмжээнд нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо Компани үндэслэлтэй бөгөөд дэмжлэг болох холбоотой бөгөөд аливаа өртөг, хүчин чармайлт гаргалгүй олж авах боломжтой мэдээллийг авч үздэг. Энэ нь компанийн түүхэн туршлага, мэдээлэлд тулгуурласан зээлийн үнэлгээ болон ирээдүйн мэдээллийг багтаасан тоон болон чанарын мэдээлэл, дүн шинжилгээг багтаадаг.

Компани нь санхүүгийн хөрөнгийн эргэн төлөлтийн хугацаа 30 хоногоос хэтэрсэн тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн гэж үздэг.

Компани санхүүгийн хөрөнгийг дараах нөхцөлд хугацаа хэтэрч, үүргээ биелүүлээгүй гэж үздэг:

- компанид зээлдэгч нь үнэт цаасыг хүчээр зарах (хэрэв байгаа бол) гэх мэт аливаа арга хэмжээ авахгүйгээр компанид эргэн төлөх үүргээ бүрэн биелүүлж чадахгүй тохиолдолд; эсвэл
- санхүүгийн хөрөнгө 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн

Гэрээний хугацаа дуусах хүртэл ХБА нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний хугацааны туршид тохиолдох боломжтой бүхий л хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх ХБА юм. 12 сарын ХБА нь тайлант жил дуусгавар болсон өдрөөс хойш 12 сарын хугацаанд (эсвэл хэрэглүүрийн гэрээний хугацаа нь 12 сараас бага бол богино хугацаанд үүссэн үйл явдал) тохиолдож болзошгүй хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх ХБА-ийн хэсэг юм.

ХБА-г тооцохдоо авч үздэг хамгийн урт хугацаа нь компанийн зээлийн эрсдэлд өртөх гэрээний хамгийн урт хугацаа юм.

ХБА нь зээлийн алдагдлын магдлалаар жигнэсэн тооцоолол юм. Зээлийн алдагдлыг бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмждэг (жишээ нь, гэрээний дагуу аж ахуйн нэгжид учирч болзошгүй мөнгөн гүйлгээний зөрүү ба Компани хүлээж авах мөнгөн гүйлгээний хоорондын зөрүү). ХБА-ыг санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтлан тооцдог.

Компани нь санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Хөрөнгийг анх бүртгэснээс хойш алдагдалд хүргэх үйл явдал болсон бөгөөд уг үйл явдлын улмаас тухайн хөрөнгийн ирээдүйд бий болгох мөнгөн урсгал буурсан байвал уг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ.



## **2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

### **2.6. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- 90 хонгоос дээш эргэн төлөх хугацаа хэтэрсэн эсвэл гэрээний үүргээ биелүүлэх чадваргүй болсон зэргээр гэрээний заалтыг зөрчсөн;
- Компанид өөр нөхцөл байхгүй байсантай холбоотой зээл болон урьдчилгаа төлбөрийн бүтцийг өөрчилсөн;
- зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай;
- санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй болсон

Хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн дансны үнээс бууруулдаг.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үнэт цаасны хувьд алдагдлын санг ашиг, алдагдлын хэсэгт тусган бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна. Корпорацийн үйлчлүүлэгчдийн хувьд, Компани нь тусдаа нөхөн төлбөрийн боломжит таамаглал байгаа эсэхийг цаг хугацаа болон дүнг харгалзан үнэлгээ хийдэг. Компани данснаас хассан дүнгээс их хэмжээний дүн нөхөгдөнө гэж үздэггүй боловч Компанийн төлбөр барагдуулах журмын дагуу данснаас хасагдсан санхүүгийн хөрөнгийг хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээ авч байж болно.

### **2.7. Урьдчилгаа төлбөр**

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгаа төлбөрийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Компани нь урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнийн цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.8. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ.

Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга ба эд хогшил	3 - 10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

### 2.9. Эздийн өмч

Энгийн хувьцааг эздийн өмчид ангилна. Шинэ хувьцаа гаргахтай холбоотой гадаад зардлууд нь эздийн өмчид бүртгэгдэх энгийн хувьцааны дүнгээс хасагдсан байдалтайгаар хүлээн зөвшөөрнө. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ болон бодит үнийн зөрүүг нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө.

Ногдол ашгийг зөвхөн тайланд өдөр болон түүнээс өмнө зарлагдсан тохиолдолд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, тайлант өдөр эздийн өмчөөс хасна. Мөн ногдол ашгийг тайлант өдрийн өмнө санал болгосон эсвэл тайлант өдөр болон санхүүгийн тайлан баталгаажих өдрийн хооронд санал болгосон тохиолдолд тодруулга хийнэ.



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10. Түрээс

(i) Түрээслэгчийн хувьд

*2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн бодлогууд*

Гэрээг анх байгуулах үед Компани нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ юу гэдгийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээсийг агуулсан гэрээ гэж үзнэ. СТОУС 16-ийн дагуу түрээсийг 'тодорхой хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ төлбөрийн солилцоогоор шилжүүлэх гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг' гэж тодорхойлсон.

Энэхүү бодлогыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш байгуулсан гэрээнүүдэд хэрэгжүүлсэн.

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Компани гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг боловч хөрөнгийн түрээсийн хувьд Компани нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгах аргыг сонгосон ба харин түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэдэг.

Компани нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг салгаж буулгах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон болон түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Түрээсийн хугацаа дуусгавар болох үед ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь худалдан авах сонголтыг тусгасан эсвэл үндсэн түрээсийн хөрөнгийг өмчлөх эрх Компанид бүрэн шилжихээс бусад үед ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дуусах өдөр хүртэл шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Энэ тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийг тухайн хөрөнгийн ашиглалтын жилээр элэгдүүлэх бөгөөд ашиглалтын жилийг үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тодорхойлох сууриар тодорхойлдог. Түүнчлэн, ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнийг аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулж, түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээр тохируулдаг.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нуугдмал хүүгийн хувь хэмжээ эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Компанийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг ашиглан дискаунталсан өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Компани нь өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн санхүүгийн эх үүсвэрээс хүүгийн хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10. Түрээс

*(i) Түрээслэгчийн хувьд*

*2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн бодлогууд (үргэлжлэл)*

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлүүд багтана:

- тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр хамаарна);
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр
- үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүн
- Компанийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд Компани түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Компанийн ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдөх, үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөлт орсон эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчилсэн тохиолдолд дахин хэмждэг.

Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохируулгыг хийх ба хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж буурсан тохиолдолд ашиг, алдагдал бүртгэдэг. Компани нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө оруулалтын зорилгоорх үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангаагүй ашиглах эрхтэй хөрөнгийг 'үндсэн хөрөнгө'-ийн ангилалд, түрээсийн өр төлбөрийг 'зээл ба өр төлбөр'-ийн ангилалд бүртгэдэг.

*Богино хугацааны түрээс, бага өртөг бүхий түрээс*

Компани бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн (үүнд оффисын түрээс багтана) хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Компани эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

*2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мөрдөж байсан бодлогууд*

Түрээсийн хөрөнгийн эзэмшлийн эрсдэл болон өгөөжийн дийлэнх хэсэг түрээслэгчид шилжсэн тохиолдолд түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилан бүртгэдэг. Бусад түрээсийг үйл ажиллагааны түрээсээр ангилдаг.

*Үйл ажиллагааны түрээс*

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг тухайн түрээсэлсэн хөрөнгийн эдийн засгийн өгөөжийг цаг хугацааны хувьд илүү бодитой илэрхийлэх аливаа системтэй үндэслэл байхгүй бол уг түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны түрээсээс үүссэн болзошгүй түрээсийн төлбөрийг үүссэн хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10. Түрээс

#### (ii) Түрээслүүлэгчийн хувьд

Түрээсийн бүрэлдэхүүн хэсэг агуулсан гэрээг анх хэрэгжиж эхлэх эсвэл өөрчлөлт орсон үед Компани нь гэрээнд тусгасан үнийг түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт тэдгээрийн тус бүрийн үнэнд суурилан хуваарилна.

Компани нь түрээслүүлэгчийн хувьд, гэрээний эхэнд тухайн түрээсийг санхүүгийн эсвэл үйл ажиллагааны түрээсийн аль болохыг тодорхойлно.

Түрээсийн ангиллыг тодорхойлохдоо Компани нь тухайн хөрөнгийг эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийн бараг бүгдийг нь шилжүүлсэн эсэхийг ерөнхий үнэлгээгээр шалгадаг. Хэрвээ шилжсэн бол тухайн түрээсийг санхүүгийн түрээс, шилжээгүй бол үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Энэхүү үнэлгээнд Компани нь хөрөнгийг эдийн засгийн ашиглах хугацааны ихээхэн хэсэгт түрээслүүлж буй эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үздэг.

Хэрвээ гэрээ нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байвал Компани нь гэрээний үнийг хуваарилахдаа СТОУС 15-г мөрддөг.

Компани нь түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтанд СТОУС 9-ын үл хүлээн зөвшөөрөлт ба үнэ цэнийн бууралтын шалгууруудыг хэрэгжүүлдэг (Тодруулга 23-г харна уу). Компани нь түрээсийн нийт хөрөнгө оруулалыг тооцоолоход ашигласан баталгаагүй үлдэгдэл үнэ цэнийг тогтмол хянаж байдаг.

Компани нь үйл ажиллагааны түрээсийн орлогод хүлээн авсан түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар "бусад орлого"-оор хүлээн зөвшөөрдөг.

Ерөнхийдөө, түрээслүүлэгчийн хувьд Компанийн мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого нь харьцуулагдах тайлант жилийн хувьд СТОУС 16-аас ялгаатай биш байсан.

#### *2019 оны 01 дүгээр сарын 01-ээс өмнө мөрдөж байсан бодлого*

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө байгуулсан гэрээнүүдийн хувьд түрээс агуулсан эсвэл түрээсийн үйл ажилаагаа эсэхийг тодорхойлохдоо дараах үнэлгээн дээр суурилдаг байсан:

- гэрээний биелэлт нь тусгайлсан хөрөнгө эсвэл хөрөнгүүдийг ашиглах эсэхээс хамаарах; мөн
- хөрөнгийн ашиглах эрхийг гэрээгээр шилжүүлсэн. Дараахаас аль нэгийг нь хангаж байвал хөрөнгийн ашиглах эрх шилжсэн гэж үзнэ:
- худалдан авагч нь тухайн хөрөнгийн гарцын өчүүхэн бага хэсгээс илүүг олж авах болон хянадаг байхын зэрэгцээ хөрөнгийг ажиллуулах чадвар болон эрхтэй байх;
- худалдан авагч нь тухайн хөрөнгийн гарцын өчүүхэн бага хэсгээс илүүг олж авах болон хянадаг байхын зэрэгцээ тухайн хөрөнгийн биет байдлыг хянах чадвар болон эрхтэй байх; эсвэл
- баримт болон үүссэн нөхцөл байдлаар гарцын өчүүхэн бага хэсгээс илүүг бусад талууд авахад салгагддаг болох нь нотлогдсон, бөгөөд нэгжийн үнэ нь гарцын нэгжид тогтмол бус ба тухайн үеийн зах зээлийн үнэтэй тэнцүү бус байх.

## **2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

### **2.11. Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт**

Хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. “Үр ашигт хүү” гэдэг нь хүлээгдэж буй хугацаан дахь ирээдүйд төлөгдөх буюу хүлээн авах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэглүүрийн дансны үнэд дискаунтчилахад ашиглаж буй хүү юм:

- санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсвэл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшинг тооцоолохдоо Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн дагуу ирээдүйн бүх мөнгөн урсгалыг тооцох боловч хүлээгдэж буй алдагдлыг тооцохгүй. Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг тооцон хүлээгдэж буй алдагдлын ирээдүйн мөнгөн урсгалыг тооцно.

Үр ашигт хүүгийн тооцоололд гүйлгээний зардал, хураамж, төлбөр хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэрэг үр ашигт хүүгийн чухал хэсгүүд багтана. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамаарах нэмэгдэл зардал багтана.

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үндсэн төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн түвшинг ашиглан анхны болон эцсийн дүнгийн зөрүүгээр хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх эсвэл хасах ба санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй аливаа зээлийн алдагдлын санг тохируулсан дүнг хэлнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ нь хүлээгдэж буй аливаа зээлийн алдагдлын санг тохируулснаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг хэлнэ.

### **2.12. Ажилчдын тэтгэмж**

Компани нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн Компани нь ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ Компани нь ажилчдынхаа үзүүлсэн өнгөрсөн үеийн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### **2.13. Нөөц**

Компани нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.13. Нөөц (үргэлжлэл)

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

### 2.14. Холбоотой тал

Компани болон Компанийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ.

- компанийг шууд эсвэл хамтран хянадаг;
- компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан.

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- тухайн аж ахуйн нэгж болон Компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм;
- нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан доор байх;
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан;

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.15. Татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлаас бүрддэг.

#### *(i) Тухайн үеийн орлогын албан татвар*

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тооцдог.

#### *(ii) Хойшлогдсон татвар*

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Гүүдвил эсвэл татвар ногдох ашиг болон нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нь нөлөөлөхгүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-гээр үүссэн бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүнүүдийн хувьд хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөр хүлээн зөвшөөрдөггүй.

Компанийг түр зөрүүний буцаалтыг хянах чадвартай ба тодорхой хугацаанд түр зөрүү нь буцаагдах магадлалтай гэсэн үндэслэлээр охин компанид орлуулсан хөрөнгө оруулалтаас үүссэн татварын түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрсөн.

Ийм төрлийн хөрөнгө оруулалттай холбоотой үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татварын хөрөнгийг зөвхөн түр зөрүүний үр өгөөжийг хүртэхэд хангалттай татвар ногдох ашиг олох магадлалтай ба тодорхой хугацаанд буцаагдах боломжтой үед хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Компани нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.15. Татвар (үргэлжлэл)

*(iii) Тайлант жилийн орлогоын татвар болон хойшлогдсон татвар*

Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгах ба харин эздийн өмчийн хэсэгт тусгагддаг зүйлстэй холбоотой бол холбогдох татварыг мөн эздийн өмчийн хэсэгт тусгадаг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Таамаглал хийхэд үүсдэг тодорхойгүй байдлын улмаас гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөллийг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн өөрчлөлт гарсан тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд уг тооцооллын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг.

*(i) Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж*

*Монгол Улсын татварын систем*

Монгол Улсын Засгийн Газар зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бизнес болон арилжааны дэд бүтцийг шинэчилсээр байгаа. Үүнтэй холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц хууль тогтоомж, дүрэм журмууд хурдацтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь зарим тохиолдолд хуулийн хангалтгүй боловсруулалт, маргаантай тайлбар, болон татварын албадын ялгаатай хэрэглээ зэрэг нөхцөл байдлыг үүсгэдэг.

Ялангуяа, татварыг хуулийн дагуу торгууль, алданги ногдуулах эрх бүхий олон тооны байгууллагууд хяналт шалгалт хийдэг. Байгууллага нь татварын хууль тогтоомжийн талаарх өөрсдийн ойлголт болон тайлант жилийн эцэс дэх санхүүгийн үр дүнд үндэслэн татварын өр төлбөрийг зохистойгоор тооцоолж илэрхийлсэн гэж үзэж байгаа боловч дээрх нөхцөл нь байгууллагад татварын эрсдэлийг үүсгэж болзошгүй ба энэхүү эрсдэлийг тоон хэмжээгээр илэрхийлэх боломжгүй юм.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

(ii) Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Тайлант хугацааны эцэст санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлсэн дүнгүүдийн тодорхойгүй байдал дахь таамаглал хийхэд ашигласан гол хүчин зүйлүүдийг доор тайлбарлав.

*Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил*

Компани үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлант жилийн эцсээр хянадаг ба хөрөнгийн ашиглалтын байдал, насжилт болон технологийн шинэчлэл зэрэг хүчин зүйлүүдийг үндэслэн тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Тэдгээр таамаглалд гарч болох өөрчлөлтүүд нь тайлант жилийн ашигт ихээхэн нөлөө үзүүлэх боломжтой. Удирдлага нь үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тэдгээрийн эдийн засгийн үр өгөөж өгөх ашиглалтын жил гэдэгт итгэж байна.

*Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан*

СТОУС 9 нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг хэмжиж, хүлээн зөвшөөрөх арга хандлагыг боловсруулсан. Компани нь түрээс бүрийн нөхцөл байдалд үндэслэн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцохдоо тайлант хугацааны эцэст санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнийг хянадаг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын түвшинг тооцохдоо ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоход ашигласан таамаглал болон удирдлагын үнэлэмжийг авч үздэг. Ирээдүйн мөнгөн урсгалын тооцоололд авч үзсэн таамаглалын аливаа өөрчлөлтийн үр дүнд үнэ цэнийн бууралтын алдагдлын сан өсөх эсвэл буурах нөлөөтэй бөгөөд Компанийн цэвэр хөрөнгийн үнэ цэнэ болон ирээдүйн ашигт мөн нөлөөлнө. Нягтлан бодох бүртгэлийн холбогдох бодлогын дэлгэрэнгүйг Тодруулга 2.6-д тайлбарласан.

### 4. Мөрдөж эхэлсэн шинээр гарсан стандартууд

Хэд хэдэн шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ. Дараах нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбарууд нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй болно:

- СТОУС-ын Стандарт дахь үзэл баримтлалын зарчимтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд
- Бизнесийн тодорхойлолт (СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт)
- Материаллаг байдлын тодорхойлолт (НББОУС 1, НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт)
- СТОУС 17 Даатгалын гэрээ.



**5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Бэлэн мөнгө	6,730	85
Харилцах данс	27,607,824	769,521
3 сар ба түүнээс бага хугацаатай хадгаламж	15,033,469	-
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(74,037)	-
	<b>42,573,986</b>	<b>769,606</b>

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай байдгаараа онцлог юм. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг барьцаагаар хангах шаардлагагүй бөгөөд хугацааны болон үнэ цэнийн бууралт тооцох үзүүлэлтээр ангилах шаардлагагүй байдаг.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон 3 сараас бага хугацаатай хадгаламжийн эрсдэлийг Стандарт энд Пүүрс, Мүүдийз болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
В3	26,997,995	338,814
Зэрэглэлгүй	15,643,298	430,707
	<b>42,641,293</b>	<b>769,521</b>

Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	-	-
Тайлант жилд нэмэгдсэн	(83,468)	-
Үнэ цэнийн бууралтын зардлын буцаалт	9,431	-
12 дугаар сарын 31-ний өдрөөр	<b>(74,037)</b>	<b>-</b>

**6. Хугацаатай хадгаламж**

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Хугацаатай хадгаламж	10,238,523	8,054,333
Хуримтлагдсан хүүгийн авлага	105,432	186,143
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(51,193)	(40,272)
	<b>10,292,762</b>	<b>8,200,204</b>

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**6. Хугацаатай хадгаламж (үргэлжлэл)**

Хугацаатай хадгаламжийн эрсдэлийг Стандарт энд Пүүрс, Мүүдийз болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
ВЗ	7,312,221	-
Зэрэглэлгүй	3,031,734	8,240,476
	<b>10,343,955</b>	<b>8,240,476</b>

Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	(40,272)	-
Тайлант жилд нэмэгдсэн	(51,193)	(40,272)
Хугацаа нь дууссан хадгаламжаас буцаасан	40,272	-
12 дугаар сарын 31-ний өдрөөр	<b>(51,193)</b>	<b>(40,272)</b>

**7. Дансны болон бусад авлага**

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Дансны авлага	66,761	60,590
Ажилчдаас авах авлага	644	1,834
Бусад авлага	657	17,024
	<b>68,062</b>	<b>79,448</b>

**8. Бусад хөрөнгө**

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Урьдчилж төлсөн төлбөр	22,405	37,195
Хангамжийн материал	28,836	14,722
	<b>51,241</b>	<b>51,917</b>

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**9. Түрээсийн авлага**

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
Түрээсийн авлага	73,903,792	67,620,792
Хуримтлагдсан хүүгийн авлага	1,595,736	663,359
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(1,047,135)	(507,894)
	<b>74,452,393</b>	<b>67,776,257</b>

Тайлангийн өдрөөрх түрээсээрх нийт хөрөнгө оруулалтын дүн ба түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн уялдааг Тодрууга 23-аас харна уу.

Түрээсийн авлагын насжилт дараах байдалтай байна:

	<b>2019</b>		<b>2018</b>	
	<b>Мян.төг</b>		<b>Мян.төг</b>	
	<b>Түрээсийн авлага</b>	<b>Үнэ цэнийн бууралтын алдагдын сан</b>	<b>Түрээсийн авлага</b>	<b>Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан</b>
Хэвийн	64,544,699	(322,723)	65,951,746	(330,975)
Хугацаа хэтэрсэн хоног				
1-30 хоног	-	-	-	-
31-90 хоног	6,691,309	(441,626)	1,669,046	(176,919)
91-180 хоног	-	-	-	-
181-360 хоног	-	-	-	-
361-ээс дээш хоног	2,667,784	(282,786)	-	-
	<b>73,903,792</b>	<b>(1,047,135)</b>	<b>67,620,792</b>	<b>(507,894)</b>

Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
01 дүгээр сарын 01-ний өдөр	(507,894)	-
Тайлант жилд нэмэгдсэн	(539,241)	(507,894)
12 дугаар сарын 31-ний өдөр	<b>(1,047,135)</b>	<b>(507,894)</b>

**10. Санхүүгийн түрээсийн зорилгоор худалдаж авсан хөрөнгө**

Компани нь уул уурхайн компанид санхүүгийн түрээсээр олгох зорилгоор санхүүгийн түрээсийн хөрөнгө болох экскаваторыг 5.9 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хөрөнгийн өмчлөл, холбогдох өгөөж ба эрсдэлүүд нь гэрээгээр болон хууль ёсоор Компанид шилжсэн. Тухайн түрээсийн санхүүжилтийг тайлант жилийн дараа олгосон. Үүний үр дүнд, Компани нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр түрээслэх зорилгоор худалдан авсан хөрөнгө бүртгэсэн.

## 11. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дараах байдалтай байна:

	Тээврийн хэрэгсэл	Ашиглах эрхтэй хөрөнгө	Компьютер	Тавилга эд хогшил	Нийт
<b>Өртөг</b>					
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	54,864	-	46,094	36,801	137,759
Нэмэгдсэн	157,000	-	37,587	39,778	234,365
Хасагдсан	(27,957)	-	-	-	(27,957)
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>183,907</b>	<b>-</b>	<b>83,681</b>	<b>76,579</b>	<b>344,167</b>
СТОУС 16-ын дагуу хүлээн зөвшөөрсөн ашиглах эрхтэй хөрөнгө	(157,000)	157,000	-	-	-
<b>2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх залруулсан үлдэгдэл</b>	<b>26,907</b>	<b>157,000</b>	<b>83,681</b>	<b>76,579</b>	<b>344,167</b>
Нэмэгдсэн	-	-	35,561	21,594	57,155
Хасагдсан	-	-	-	(10,409)	(10,409)
<b>2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>26,907</b>	<b>157,000</b>	<b>119,242</b>	<b>87,764</b>	<b>390,913</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	(3,440)	-	(6,512)	(1,772)	(11,724)
Тайлант жилд байгуулсан	(14,565)	-	(18,794)	(5,911)	(39,271)
Хасагдсан	2,270	-	-	-	2,270
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	(15,735)	-	(25,306)	(7,683)	(48,724)
СТОУС 16-ын дагуу хүлээн зөвшөөрсөн ашиглах эрхтэй хөрөнгө	7,570	(7,570)	-	-	-
<b>2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх залруулсан үлдэгдэл</b>	<b>(8,165)</b>	<b>(7,570)</b>	<b>(25,306)</b>	<b>(7,683)</b>	<b>(48,724)</b>
2019 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	(8,165)	(7,570)	(25,306)	(7,683)	(48,724)
Тайлант жилд байгуулсан	(6,727)	(15,700)	(33,685)	(9,848)	(65,960)
Хасагдсан	-	-	-	1,108	1,108
<b>2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>(14,892)</b>	<b>(23,270)</b>	<b>(58,991)</b>	<b>(16,423)</b>	<b>(113,576)</b>
<b>Дансны үнэ</b>					
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	168,172	-	58,375	68,896	295,443
2019 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	18,742	149,430	58,375	68,896	295,443
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	12,015	133,730	60,251	71,341	277,337



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**12. Дансны болон бусад өглөг**

	2019 Мян.төг	2018 Мян.төг
Дансны өглөг	161,673	5,991,233
Татварын өглөг	14,829	679
Бусад өглөг	6,202	1,655
	<b>182,704</b>	<b>5,993,567</b>

**13. Түрээсийн өр төлбөр**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх түрээсийн өр төлбөр (2018: Санхүүгийн түрээсийн өр төлбөр) дараах байдалтай байна:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2019 Мян.төг	
					Богино хугацаат	Урт хугацаат
Хаан Банк ХХК	Төгрөг	15%	10/7/2018	23/7/2023	26,500	85,315
					<b>26,500</b>	<b>85,315</b>

	2018 Мян.төг		
	Түрээсийн ирээдүйн хамгийн бага төлбөр	Хүү	Түрээсийн хамгийн бага төлбрийн өнөөгийн үнэ цэнэ
Нэг жилээс бага	40,800	(17,691)	23,109
Нэг жилээс их	143,797	(32,672)	111,125
<b>Нийт</b>	<b>184,597</b>	<b>(50,363)</b>	<b>134,234</b>

**14. Зээл**

	2019 Мян.төг	2018 Мян.төг
Богино хугацаат зээл	3,645,623	8,535,213
Урт хугацаат зээл	20,752,545	57,083,810
Хуримтлагдсан хүүгийн өглөг	171,287	505,107
	<b>24,569,455</b>	<b>66,124,130</b>

**14. Зээл (үргэлжлэл)**

(1) Богино хугацаат зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2019 Мян.төг	2018 Мян.төг
Монгол Улсын Хөгжлийн Банк	Ам.Доллар	3.60%	28/7/2017	28/7/2022	2,376,861	2,725,926
(*)	Иен	5.95%	16/11/2017	29/5/2020	-	1,088,823
	Иен	4.89%	10/4/2018	10/4/2021	-	1,619,266
	Иен	4.89%	24/5/2018	10/4/2021	-	878,646
	Иен	6.50%	12/9/2018	12/9/2023	-	296,754
	Иен	6.50%	13/11/2018	12/9/2023	-	299,320
	Иен	6.50%	18/10/2018	12/9/2023	-	546,453
Сангийн Яам (**)	Төгрөг	2.25%	21/12/2017	28/7/2028	1,268,762	1,080,025
					<b>3,645,623</b>	<b>8,535,213</b>

(2) Урт хугацаат зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2019 Мян.төг	2018 Мян.төг
Монгол Улсын Хөгжлийн Банк	Ам.Доллар	3.60%	28/7/2017	28/7/2022	13,522,600	17,826,542
(*)	Иен	5.95%	16/11/2017	29/5/2020	-	2,964,207
	Иен	4.89%	10/4/2018	10/4/2021	-	2,185,185
	Иен	4.89%	24/5/2018	10/4/2021	-	1,185,725
	Иен	6.50%	12/19/2018	12/9/2023	-	2,601,258
	Иен	6.50%	13/11/2018	12/9/2023	-	2,623,768
	Иен	6.50%	18/10/2018	12/9/2023	-	4,790,052
	Евро	3.12%	20/26/2018	20/6/2023	-	14,179,071
	Евро	7.42%	6/12/2018	6/12/2023	-	479,359
Сангийн Яам (**)	Төгрөг	2.25%	21/12/2017	28/7/2028	7,229,945	8,248,643
					<b>20,752,545</b>	<b>57,083,810</b>

(\*) 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн #04 тоот Хувьцаа Эзэмшигчийн Шийдвэрийн дагуу Монгол Улсын Хөгжлийн Банкнаас 2018 болон 2019 онуудад авсан зээлээс 50,000,000 мянган төгрөгийн зээлийг хугацаанаас нь өмнө, 5,238,181 мянган төгрөгийг хугацаанд нь төлж барагдуулсан.

(\*\*) Компани нь 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Сангийн Яам болон Зам Тээврийн Хөгжлийн Яамтай 11,610 сая төгрөгийн дүнтэй "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-г байгуулсан ба энэхүү эх үүсвэрээр улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл нийлүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Санхүүгийн түрээсийн авлагын эргэн төлөлтөөс хамааран уг санхүүжилтийн эргэн төлөх хугацаа болон үнийн дүн нь харилцан адилгүй байна.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**15. Хувьцаат капитал**

	Энгийн хувьцааны тоо		Хувьцаат капитал	
	2019 Мян.төг	2018 Мян.төг	2019 Мян.төг	2018 Мян.төг
01 дүгээр сарын 01-нээрх	200,000	200,000	10,000,000	10,000,000
Нэмж гаргасан	1,800,000	-	90,000,000	-
12 дугаар сарын 31-нээрх	<u>2,000,000</u>	<u>200,000</u>	<u>100,000,000</u>	<u>10,000,000</u>

2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн #04 тоот Хувьцаа Эзэмшигчийн Шийдвэрийн дагуу нэг бүр нь 50 мянган төгрөгийн үнэтэй 1,800,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах замаар хувьцаат капиталыг 90,000,000 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Үүний үр дүнд, нийт зөвшөөрсөн ба гаргасан хувьцаат капитал нь 2,000,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 50 мянган төгрөг ба 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нийт хувьцаат капитал нь 100,000,000 мянган төгрөг байна.

**16. Хүүгийн орлого**

	2019 Мян.төг	2018 Мян.төг
Түрээсийн авлага	5,899,771	3,055,137
Хугацаатай хадгаламж	619,874	1,133,424
Харилцах данс	538,456	51,313
	<u>7,058,101</u>	<u>4,239,874</u>

**17. Хүүгийн зардал**

	2019 Мян.төг	2018 Мян.төг
Зээл	(3,057,531)	(2,176,437)
Түрээсийн өр төлбөр (2018: Санхүүгийн түрээсийн өр төбөр)	(18,381)	(9,934)
	<u>(3,075,912)</u>	<u>(2,186,371)</u>

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**18. Үйл ажиллагааны зардал**

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
Цалингийн зардал	(1,262,612)	(636,703)
Нийгмийн даатгалын зардал	(152,498)	(78,542)
Албан томилолтын зардал	(153,598)	(115,425)
Богино хугацаат түрээсийн зардал	(143,162)	(87,857)
Мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний зардал	(79,566)	(11,819)
Элэгдэл болон хорогдол	(66,820)	(39,271)
Зар сурталчилгаа ба маркетингийн зардал	(24,478)	(1,100)
Тээвэр ба шатахууны зардал	(19,970)	(10,417)
Сургалтын зардал	(14,939)	(1,112)
Бусад зардал (*)	(138,962)	(75,686)
	<b>(2,056,605)</b>	<b>(1,057,932)</b>

(\*) Бусад зардалд интернэт, харилцаа холбооны зардал болон бусад удирдлагын зардлууд багтсан.

**19. Бусад орлого, цэвэр**

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
Ханшийн тэгшитгэлийн хэрэгжсэн олз	31,351	232,078
Ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй олз (гарз), цэвэр	823,411	153,097
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	-	1,338
Бусад орлого	1,247	636
	<b>856,009</b>	<b>387,149</b>

**20. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал**

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
Түрээсийн авлага	(539,241)	(507,894)
Хугацаатай хадгаламж	(10,921)	(40,272)
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	(74,037)	-
	<b>(624,199)</b>	<b>(548,166)</b>



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**21. Орлогын татварын зардал**

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Тайлант жилийн татварын зардал	(143,104)	(127,161)
Хойшлогдсон татварын зардал	(82,341)	-
	<b>(225,445)</b>	<b>(127,161)</b>

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон өдрийн татварын өмнөх орлогоос татварын нийтлэг хувь хэмжээгээр тооцоолсон орлогын татварын зардлыг дараах байдлаар тооцоолно:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Татварын өмнөх ашиг	2,157,394	834,554
Нийтлэг хувь хэмжээгээр тооцсон татвар	(215,739)	(83,455)
Татвараас хасагдахгүй зардлын нөлөөлөл	(8,010)	(59,015)
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	114,137	133,783
Тусгай хувь хэмжээгээр ногдох татвар	(115,833)	(118,474)
	<b>(225,445)</b>	<b>(127,161)</b>

(\*) Компани нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу 2019 оныг дуустал 3 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлогод 10 хувь, 3 тэрбумаас давсан татвар ногдуулах орлогод 25 хувиар орлогын албан татвар ногдуулж, төлөх үүрэгтэй. 2020 оноос эхлэн татварын шинэ хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдуулах орлогод 25 хувийн татвар ногдуулна.

	<b>2019</b> <b>MNT'000</b>	<b>2018</b> <b>MNT'000</b>
<b>Хойшлогдсон татварын (өглөг) / хөрөнгө</b>		
Тайлант жилийн эхэнд	-	-
Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй олз	(82,341)	-
<b>Тайлант жилийн эцэст</b>	<b>(82,341)</b>	<b>-</b>

**22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ****(i) Холбоотой талуудын харилцан хамаарал**

Дараах байгууллагууд нь Компанийн холбоотой талууд болно.

<b>Байгууллагын нэр</b>	<b>Харилцан хамаарал</b>
Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ)	Дээд шатны хяналт тавих байгууллага
Сангийн яам (СЯ)	Дунд шатны хяналт тавих байгууллага
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (МУХБ)	Толгой компани
Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	Зэргэлдээ компани
Төрийн Банк ХХК	МУЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллага
Бусад засгийн газрын байгууллагууд	МУЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллагууд

**(ii) Холбоотой талуудын үлдэгдэл**

Тайлант хугацааны эцэс дэх үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
<b>Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:</b>		
Харилцах данс	8,424	69,643
Зээл	15,899,461	56,290,355
Зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг	73,704	398,253
<b>Сангийн Яам:</b>		
Зээл	8,498,707	9,328,668
Зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг	97,583	106,855
<b>Төрийн Банк ХХК:</b>		
Харилцах данс	1,085,497	268,460
<b>Бусад засгийн газрын байгууллагууд:</b>		
Түрээсийн авлага	43,270,490	39,755,687
Түрээсийн авлагын хуримтлагдсан хүүгийн авлага	503,949	561,848
Түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(216,352)	(248,236)

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

### (iii) Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээнүүд дараах байдалтай байна:

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
<b>Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:</b>		
Зээлийн хүүгийн зардал	2,730,159	1,999,238
Капиталын хөрөнгө оруулалт – хувьцаа гаргалт	90,000,000	-
<b>Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК</b>		
Зардлын буцаан олголт	8,000	-
<b>Сангийн Яам:</b>		
Зээлийн хүүгийн зардал	197,345	174,561
<b>Төрийн Банк ХХК:</b>		
Харилцах дансны хүүгийн орлого	48,770	19,558
Хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого	-	291,976
<b>Бусад засгийн газрын байгууллагууд:</b>		
Түрээсийн авлагын хүүгийн орлого	2,029,045	1,812,161

### (iv) Уудирдлагын голлох ажилтнуудын цалин, урамшуулал

Удирдах гол албан тушаалтнууд нь Гүйцэтгэх Захирал болон нэгжүүдийн захирлууд юм. Захиралууд болон бусад удирдлагын голлох ажилтнуудын тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна.

	<b>2019</b> <b>Мян.төг</b>	<b>2018</b> <b>Мян.төг</b>
Цалин урамшуулал	338,356	264,615
Нийгэм, эрүүл мэндийн даатгалын зардал	42,293	31,754
	<b>380,649</b>	<b>296,369</b>

Удирдах гол албан тушаалтнуудын цалин урамшуулал нь цалин болон ажил олгогчоос төлсөн нийгмийн, эрүүл мэндийн даатгалаас бүрдэнэ.



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**23. Түрээслүүлэгчийн хувьд санхүүгийн түрээс**

Тайлагналын өдрөөс хойш хүлээн авах дискаунтчилаагүй түрээсийн төлбөрийг дуусах хугацаагаар ангилан дараах хүснэгтээр харуулбал:

	<b>2019</b>
	<b>Мян.төг</b>
Санхүүгийн түрээсийн авлагын нийт хөрөнгө оруулалт	
Нэг жилээс бага	24,617,825
Нэгээс хоёр жил	24,620,419
Хоёроос гурван жил	20,226,870
Гурваас дөрвөн жил	7,810,982
Дөрвөөс таван жил	1,626,218
Таваас дээш жил	3,881,694
Нийт түрээсийн авлагын дискаунтчилаагүй дүн	82,784,008
Хойшлогдсон санхүүгийн орлого	(8,331,615)
Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт	<b>74,452,393</b>

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн түрээсийн авлагын нийт хөрөнгө оруулалт ба түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн уялдаа дараах байдалтай байна:

	<b>2019</b>
	<b>Мян.төг</b>
Санхүүгийн түрээсийн авлагын нийт хөрөнгө оруулалт	
Нэг жилээс бага	13,961,656
Нэг болон түүнээс дээш жил	68,753,986
	82,715,642
Хойшлогдсон санхүүгийн орлого	(14,939,385)
Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	<b>67,776,257</b>
Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	
Нэг жилээс бага	11,440,022
Нэг болон түүнээс дээш жил	56,336,235
	<b>67,776,257</b>

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага**

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашигласнаар дараах эрсдэлүүдийг хүлээж байдаг.

- Төлөгдөх байдлын эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Зах зээлийн эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн Компанид нөлөөлөх нөлөөлөл, уг эрсдэлийг тооцоолох, Компанийн зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн Компанийн хөрөнгийн удирдлагын талаарх мэдээллийг агуулсан. Компани нь эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд Түрээсийн Хороог байгуулсан.

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)****(i) Төлөгдөх байдлын эрсдэл**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь төлөгдөх байдлын эрсдэлийн удирдлагын үүрэг хариуцлагыг Түрээсийн Хороонд шилжүүлсэн. Түрээсийн Хороо нь сар бүрийн эцэст Түрээсийн Хорооны хурлаар түрээсийн багцын чанар, гүйцэтгэлийг хянан хэлэлцдэг бөгөөд түрээсийн багц дахь бүх эрсдэлийг удирдах, хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянаж байдаг.

Компани өөрийн сургалт, удирдлагын стандарт болон журамыг ашиглан ажилчид нь өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ойлгосон, дэг журамтай, бүтээлч хяналтын орчныг бий болгохоор зорьж ажилладаг.

Санхүүгийн түрээсийн эрсдэл гэдэг нь Түрээслэгч тал Санхүүгийн Түрээсийн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас Компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд энэ нь голдуу Компанийн түрээсийн үйл ажиллагааны авлагаас үүдэлтэй байдаг.

Санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ нь хамгийн их төлөгдөх байдлын эрсдэлийг илэрхийлнэ. Санхүүгийн тайлагналын өдрөөрх хамгийн их төлөгдөх байдлын эрсдэл дараах байдалтай байна:

	<b>2019</b>	<b>2018</b>
	<b>Мян.төг</b>	<b>Мян.төг</b>
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	42,567,256	769,521
Хугацаатай хадгаламж	10,292,762	8,200,204
Дансны болон бусад авлага	68,062	79,448
Бусад хөрөнгө (*)	22,405	37,195
Түрээсийн авлага	74,452,393	67,776,257
	<b>127,402,878</b>	<b>76,862,625</b>

(\*) Хангамжийн материал агуулагдаагүй

**Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө болон хугацаатай хадгаламж**

Компанийн төлөгдөх байдлын эрсдэлд өртөх байдал нь гол төлөв Компанийн хадгаламж байршуулсан банкуудын онцлог шинж чанараас хамаардаг. Компанийн удирдлага нь банк тус бүрийн төлөх чадварыг тогтоох эрсдэлийн бодлогыг нэвтрүүлсэн.

Компанийн үнэлгээнд гадны үнэлгээ, хэрэв боломжтой бол санхүүгийн тайлангууд, байгууллагын мэдээлэл, зах зээлийн мэдээлэл болон зарим тохиолдолд Монголбанкны лавлагаа орно.

Компани нь Монгол Улсын эдийн засгийн орчин, банкны салбарыг ажиглаж, эдийн засгийн нөхцөл байдалд аливаа хүндрэл үүсэх тохиолдолд үүсч болох эрсдэлийг хязгаарлах бодлого баримталдаг. Компанийн банкны дансууд хугацаа хэтрэлтгүй байна.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(i) Төлөгдөх байдлын эрсдэл (үргэлжлэл)**

*Түрээсийн авлага*

Компанийн түрээсийн авлагын эрсдэл нь голдуу худалдан авагч тус бүрийн хувийн онцлогоос хамааралтай байдаг. Удирдлага нь түрээсийн авлагын эрсдэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс болох харилцагчдын үйл ажиллагаагаа явуулж буй улс орон болон тухайн салбарын төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл зэрэг Компанийн харилцагчдын онцлогыг харгалзан үздэг.

Компанийн стандарт нөхцлийг харилцагчдад санал болгохоос өмнө компани нь шинэ харилцагч тус бүрийн эргэн төлөх чадварыг тусгайлан шинжилж, эрсдэлийн бодлогоо боловсруулдаг.

Компанийн хяналт нь гадаад үнэлгээг авч үздэг, үүнд боломжтой бол санхүүгийн тайлан, зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, бизнесийн салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд банкны лавлагаа, тодорхойлолт багтдаг.

Харилцагч тус бүрээр төлбөр төлөх дэлгэрэнгүй хуваарь гаргах байдлаар түрээсийн авлагаас хүлээх эрсдэлийг хязгаарладаг. Компани харилцагчийн эрсдэлийг тус бүрт нь хянадаг. Компанийн стандарт, бодлого журамд зааснаар санхүүгийн түрээсийн гэрээний төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд түрээслэгчийн санхүүгийн хөрөнгийг эзэмших эрхтэй байх ёстой. Компани нь түрээслэгчийн эрсдэл болон санхүүгийн түрээсийн эх үүсвэрээс хамаараад урьдчилгаа төлбөрийг 15 – 30% хооронд байршуулахыг шаарддаг.

Компани нь мөн түрээсийн авлагын эрсдэлийн төвлөрлийг салбараар нь хянадаг ба эдгээр нь ихэвчлэн газар тариалан, тээвэр логистик, уул уурхайн салбарууд байна.

*Эрсдэлийн төвлөрлийн салбараар нь харуулбал*

Дараах хүснэгтээр Компанийн түрээсийн авлагын (Тодруулга 9) нийт дүнг үйлдвэрлэлийн салбараар нь харуулав.

	2019		2018	
	Мян.төг	%	Мян.төг	%
Газар тариалан, ой мод	39,223,817	51.95%	35,283,221	46.73%
Тээвэр ба логистик	18,752,505	24.84%	19,977,826	26.46%
Уул уурхай, карьер	12,476,010	16.52%	11,945,407	15.82%
Үйлдвэрлэл	5,047,196	6.69%	1,077,697	1.43%
	<b>75,499,528</b>	<b>100.00%</b>	<b>68,284,151</b>	<b>100.00%</b>
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(1,047,135)		(507,894)	
	<b>74,452,393</b>		<b>67,776,257</b>	



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### (i) Төлөгдөх байдлын эрсдэл (үргэлжлэл)

Дараах хүснэгтээр Компанийн түрээсийн авлагын нийт дүнг салбараар нь харуулав.

	2019 Мян.төг	2018 Мян.төг
Улсын салбар	43,774,439	41,989,028
Хувийн салбар	31,725,089	26,295,123
	<b>75,499,528</b>	<b>68,284,151</b>
Үнэ цэнийн бууралтын сан	(1,047,135)	(507,894)
	<b>74,452,393</b>	<b>67,776,257</b>

Түрээсийн авлагын эрсдэл болон барьцаа хөрөнгө нь дараах байдалтай байна.

	2019 Мян.төг		2018 Мян.төг	
	Түрээсийн авлагын эрсдэл	Барьцаа хөрөнгө	Түрээсийн авлагын эрсдэл	Барьцаа хөрөнгө
Түрээсийн авлага	74,452,393	113,498,789	67,776,257	84,775,580
	<b>74,452,393</b>	<b>113,498,789</b>	<b>67,776,257</b>	<b>84,775,580</b>

2019 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хугацаа хэтэрсэн болон үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө дараах байдалтай байна:

	Хугацаа ч хэтэрээгүй үнэ цэнэ ч буураагүй	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буурсан	Нийт
<b>2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	42,567,256	-	-	42,567,256
Мөнгөн хадгаламж	10,292,762	-	-	10,292,762
Дансны болон бусад авлага	68,062	-	-	68,062
Бусад хөрөнгө (*)	22,405	-	-	22,405
Түрээсийн авлага	65,817,712	6,249,683	2,384,998	74,452,393
	<b>118,768,197</b>	<b>6,249,683</b>	<b>2,384,998</b>	<b>127,402,878</b>
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	769,521	-	-	769,521
Мөнгөн хадгаламж	8,200,204	-	-	8,200,204
Дансны болон бусад авлага	79,448	-	-	79,448
Бусад хөрөнгө (*)	37,195	-	-	37,195
Түрээсийн авлага	66,284,130	1,492,127	-	67,776,257
	<b>75,370,498</b>	<b>1,492,127</b>	-	<b>76,862,625</b>

(\*) Хангамжийн материал агуулагдаагүй

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)****(ii) Хөрвөх чадварын эрсдэл**

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компаний нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

Дараах хүснэгтэнд 2019 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг гэрээгээр хүлээсэн үүргийн эргэн төлөлтийн дискаунтчлаагүй дүнд суурилан багцын дуусах хугацаагаар нь ангилан харууллаа:

	2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх					Нийт
	3 сар хүртэлх	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5 жилээс дээш	
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	42,763,367	-	-	-	-	42,763,367
Хугацаатай хадгаламж Дансны болон бусад авлага	-	9,016,224	1,853,775	-	-	10,869,999
Бусад хөрөнгө (*)	68,062	-	-	-	-	68,062
Түрээсийн авлага	22,405	-	-	-	-	22,405
	5,460,472	5,169,257	13,988,096	54,284,489	3,881,694	82,784,008
	<b>48,314,306</b>	<b>14,185,481</b>	<b>15,841,871</b>	<b>54,284,489</b>	<b>3,881,694</b>	<b>136,507,841</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Дансны болон бусад өглөг	33,012	-	149,692	-	-	182,704
Түрээсийн өглөг	10,200	10,200	20,400	103,005	-	143,805
Зээл	837,160	10,200	3,427,472	18,503,589	3,632,075	26,410,496
	<b>880,372</b>	<b>20,400</b>	<b>3,597,564</b>	<b>18,606,594</b>	<b>3,632,075</b>	<b>26,737,005</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>47,433,934</b>	<b>14,165,081</b>	<b>12,244,307</b>	<b>35,677,895</b>	<b>249,619</b>	<b>109,770,836</b>

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### (ii) Хөрвөх чадварын эрсдэл (үргэлжлэл)

	2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх					Нийт
	3 сар хүртэлх	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5 жилээс дээш	
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	769,606	-	-	-	-	769,606
Хугацаатай хадгаламж	3,903,328	-	-	4,552,935	-	8,456,263
Дансны болон бусад авлага	79,448	-	-	-	-	79,448
Бусад хөрөнгө (*)	37,195	-	-	-	-	37,195
Түрээсийн авлага	3,223,269	3,925,465	8,193,246	61,638,576	5,735,086	82,715,642
	<b>8,012,846</b>	<b>3,925,465</b>	<b>8,193,246</b>	<b>66,191,511</b>	<b>5,735,086</b>	<b>92,058,154</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Дансны болон бусад өглөг	5,993,567	-	-	-	-	5,993,567
Түрээсийн өглөг	10,200	10,200	20,400	143,797	-	184,597
Зээл	2,610,986	2,540,703	7,926,305	62,184,794	4,548,140	79,810,928
	<b>8,614,753</b>	<b>2,550,903</b>	<b>7,946,705</b>	<b>62,328,591</b>	<b>4,548,140</b>	<b>85,989,092</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>(601,907)</b>	<b>1,374,562</b>	<b>246,541</b>	<b>3,862,920</b>	<b>1,186,946</b>	<b>6,069,062</b>

(\*) Хангамжийн материал агуулагдаагүй

### (iii) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, санхүүгийн түрээс болон гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь хүлээн зөвшөөрөгдөх параметерүүдийн хүрээнд эрсдлийг хянах, удирдсанаар эрсдлийн өгөөжийг хамгийн оновчтой байлгах явдал юм.

#### Гадаад валютын ханшийн эрсдэл

Компани нь үйл ажиллагааны валют болон төгрөгөөс өөр гадаад валютаарх түрээсийн авлага болон зээлээс валютын эрсдэл үүсдэг. Эдгээр ажил гүйлгээнүүд хийгддэг валютууд нь Ам.Доллар, Евро болон Японы Иен байна. Компани нь гадаад валютын хэлбэлзэлийг тогтмол хянадаг ба валютын эрсдэлийг бууруулах зорилгоор ирээдүйд хийгдэх гадаад валютаарх мөнгөн урсгалыг хянадаг.



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

## 24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### (iii) Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Гадаад валютын ханшийн эрсдэл (үргэлжлэл)

Компанийн валютын эрсдэл дараах байдалтай байна:

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх (Мян.төг)	Төгрөгөөрх	Гадаад валютаарх	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	36,736,945	5,837,041	42,573,986
Хугацаатай хадгаламж	10,292,762	-	10,292,762
Дансны болон бусад авлага	68,062	-	68,062
Бусад хөрөнгө (*)	22,405	-	22,405
Түрээсийн авлага	19,944,961	54,507,432	74,452,393
	<b>67,065,135</b>	<b>60,344,473</b>	<b>127,409,608</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	32,830	149,874	182,704
Түрээсийн өглөг	111,815	-	111,815
Зээл	8,596,291	15,973,164	24,569,455
	<b>8,740,936</b>	<b>16,123,038</b>	<b>24,863,974</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>58,324,199</b>	<b>44,221,435</b>	<b>102,545,634</b>
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх (Мян.төг)</b>	<b>Төгрөгөөрх</b>	<b>Гадаад валютаарх</b>	<b>Нийт</b>
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	538,670	230,936	769,606
Хугацаатай хадгаламж	7,678,857	521,347	8,200,204
Дансны болон бусад авлага	27,431	52,017	79,448
Бусад хөрөнгө (*)	37,195	-	37,195
Түрээсийн авлага	10,469,825	57,306,432	67,776,257
	<b>18,751,978</b>	<b>58,110,732</b>	<b>76,862,710</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	5,920,979	72,588	5,993,567
Санхүүгийн түрээсийн өглөг	134,234	-	134,234
Зээл	9,435,523	56,688,607	66,124,130
	<b>15,490,736</b>	<b>56,761,195</b>	<b>72,251,931</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>3,261,242</b>	<b>1,349,537</b>	<b>4,610,779</b>

(\*) Хангамжийн материал агуулагдаагүй

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

**Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(iii) Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

2019 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гадаад валютын ханш 10 хувиар чангарах эсвэл сулрахад дэлгэрэнгүй дараах хүснэгтэнд харуулсан дүнгээр буюу орлогыг татварын дараах байдлаар өсгөх (бууруулах) нөлөөтэй байна. Энэ шинжилгээ нь бусад бүх хувьсах хүчин зүйлсийг, тодруулбал хүүгийн хувь хэмжээг тогтмол гэж авч үзсэн болно.

	<u>10%-иар чангарах</u> <u>Мян.төг</u>	<u>10%-иар Сулрах</u> <u>Мян.төг</u>
<b>2019</b>		
12 дугаар сарын 31-ний өдрөөр	3,979,929	(3,979,929)
<b>2018</b>		
12 дугаар сарын 31-ний өдрөөр	121,458	(121,458)

*Хүүгийн түвшний эрсдэл*

Хүүгийн түвшний эрсдэл нь ирээдүйд хүүгийн түвшний хэлбэлзэл тэр дундаа хадгаламж болон зээлийн хөвөгч хүүнээс үүсэх эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдлийн удирдлагын гол зорилго нь санхүүгийн зардал болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхойгүй байдлыг багасгахад явдал юм.

Компанийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамааралтай зах зээлийн эрсдэл нь Компанийн зээлтэй үндсэндээ холбоотой байна.

**Багц**

Эрсдэлийг бууруулах Компанийн бодлого нь тогтмол хүүгийн түвшинтэй зээл авах юм. Тайлангийн өдрөөрх Компанийн хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн багц дараах байдалтай байна:

	<u>2019</u> <u>Мян.төг</u>	<u>2018</u> <u>Мян.төг</u>
<b>Тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө:</b>		
Санхүүгийн хөрөнгө	127,402,878	76,862,625
Санхүүгийн өр төлбөр	24,863,974	72,251,931
	<u>152,266,852</u>	<u>149,114,556</u>

**(iv) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ**

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн банкны хадгаламж, түрээсийн авлага, дансны болон бусад хадгаламжаас бүрдэнэ.

Удирдлага санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

### 25. Капиталын эрсдэлийн удирдлага

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд банкин дахь дансны үлдэгдэл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог.

Компанийн капиталын бүтэц нь банкин дахь дансны үлдэгдэл, зээл, эздийн өмч ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

### 26. Балансын дараах үйл явдал

#### КОВИД-19

Дэлхий даяар тархаад байгаа КОВИД-19 дэгдэлтээс сэргийлэх үүднээс дэлхийн улс орнуудын засгийн газар, түүний дотор Монгол Улсын засгийн газар эдийн засгийн үйл ажиллагаа, худалдаанд ихээхэн нөлөөлөхүйц хязгаарлалтуудын арга хэмжээнүүдийг авсан. Үүний үр дүнд олон улс орнуудын, түүний дотор Монгол Улсын эдийн засаг нэлээд удааширч, үүнтэй холбоотой сөрөг үр дагаврыг мэдэрч байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Онцгой байдлын комисс 2020 оны 2 болон 3 дугаар саруудад Хятад Улс руу нүүрс тээвэрлэх ажлыг нэг сар орчим хугацаанд зогсоож, улсын хил дээрх хяналт шалгалтыг нэмэгдүүлэв. Монгол Улсын Засгийн Газар нөхцөл байдлыг харгалзан аж ахуйн нэгжүүд болон иргэдэд зориулан 5 гаруй их наяд төгрөгийн өртөг бүхий эдийн засгийг дэмжих томоохон хөтөлбөр хэрэгжүүлэх болсоноо зарласан.

Тээвэрлэлтийн удаашрал, хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах, бизнесийн үйл ажиллагааны ажлын цагийг багасгах зэрэг нь тус улсын эдийн засаг, Компанийн үйлчлүүлэгчдийг багтаасан аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үзүүлэлтэд нөлөөлж буй өөрчлөлтүүд юм. Эдгээр нь Компанийн үйлчлүүлэгчдийн санхүүгийн үйл ажиллагааг бууруулж, үүнээс шалтгаалан түрээсийн эргэн төлөлтөнд доголдол үүсэх зэрэг асуудлууд нэмэгдэж болзошгүй байна. Санхүүгийн тайлан гарах үед КОВИД 19-ийн нөлөөлөл тодорхой бус байгаа бөгөөд эдгээр үйл явдлын Компанид үзүүлэх үр дагавар нь цаг хугацаанаас хамаарна.

### 27. Монгол орчуулга

Энэхүү санхүүгийн тайланг Англи болон Монгол хэл дээр бэлтгэсэн болно. Монгол болон Англи хэл дээрх хувилбаруудын хооронд утга болон агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбарыг баримтална.